



ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2018.08.06-08.10

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: АНУ-ын компаниудын хувьцааны ханш өөр өөр үзүүлэлттэй хаагдлаа. S&P 500 индексийн сагсанд багтдаг мэдээлэл технологийн салбарт үйл ажиллагаагаа явуулдаг компаниудын хувьцааны ханш өссөн бол үл хөдлөх хөрөнгийн салбарын компаниудын хувьцааны ханш унав. FactSet байгууллага S&P 500 индексийн сагсанд багтдаг компаниудын нийт орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 24.6%-аар өснө хэмээн таамагласан нь хувьцаат компаниудын тайлан гарч эхлэхээс өмнөх үеийн урьдчилсан таамгаас өндөр байгаа ажээ.

Цахилгаан авто машин үйлдвэрлэгч “Тесла” компанийн гүйцэтгэх захирал Илон Маск тус компанийг хувьчлах талаар хэлэлцээр хийж байгаа талаар мэдээлжээ. Үүний дараа “Тесла” компанийн хувьцааны ханш огцом өссөн ч, хоёр өдрийн дараагаар унасан байна. Учир нь хөрөнгө оруулагчид хэлэлцээр амжилттай болох эсэхэд эргэлзэж байгаа аж.

Туркийн Засгийн газар АНУ-ын шашны номлогчийг хорьсноос болж АНУ-ын Ерөнхийлөгч Турк улсаас импортоор орж ирж буй ган, хөнгөнцагаанд ногдуулсан гаалийн татварын хэмжээг хоёр дахин өсгөнө хэмээн мэдэгдлээ. Энэ долоо хоногт Туркийн лир болон зарим хөгжиж буй орнуудын валютын ханш унажээ. Мөн БНХАУ, АНУ хоорондын худалдааны маргаан даамжирч, БНХАУ 16 тэрбум ам.доллартай тэнцэх АНУ-ын импортод татвар ногдуулах талаар мэдэгдэл хийлээ.

Европ: Худалдааны маргааны асуудал даамжирч, Туркийн лирийн ханш суларсантай холбоотойгоор Европын компаниудын хувьцааны ханш уналттай хаагджээ. Лирийн ханш унаж, Европын банкуудын хувьцааны ханш сулрав.

АНУ нь БНХАУ-ын 16 тэрбум ам.долларын импортод 25 хувийн гаалийн татвар нэмж ногдуулах талаар мэдэгдсэн нь зах зээлийн индексүүдийг буурахад нөлөөлөв. Financial Times агентлагийн мэдээлснээр Туркийн томоохон зээлдэгчид болох Испани улсын “BBVA”, Итали улсын “UniCredit” болон Франц улсын “BNP Paribas” банкууд лирийн ханшийн уналтаас үүдэн ихээхэн алдагдал хүлээж байгаа талаар мэдээллээ. 2018 онд Туркийн лир ам.долларын эсрэг 30%-аар суларсан бол энэ долоо хоногт хамгийн доод цэгтээ хүрчээ. АНУ Туркийн импортын гаалийн татварыг 2 дахин нэмнэ хэмээн мэдээлсний дараа Европын зах зээлийн индексүүд ахин унажээ.

Япон: Японы компаниудын хувьцааны ханш уналттай хаагдлаа. Иенийн ханш ам.долларын эсрэг 1 орчим хувь чангарч 111.1 болов.

Энэ оны 2-р улиралд Япон улсын өрхийн болон ААН-үүдийн зарлага ихэсч эдийн засагт түлхэц үзүүллээ. Эхний хагас жилийн байдлаар Японы эдийн засаг 1.9 хувиар өсжээ. 1-р улиралд тус улсын эдийн засгийн өсөлт 0.9 хувьтай тэнцэж байсан билээ.

2-р улирлын байдлаар ДНБ 0.5 хувиар өссөн нь таамаглаж байсан түвшнээс өндөр гарчээ. Нийт эдийн засгийн 60 орчим хувийг бүрдүүлдэг дотоодын хэрэглээ 0.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнд, авто машин болон орон сууцны хэрэглээ нэмэгдсэн нь голчлон нөлөөлжээ.

БНХАУ: Туркийн лирийн ханш унасантай холбоотойгоор юанийн ханш 0.47 хувиар чангарлаа.

ОХУ: Биохимийн зэвсэг ашигласан байж болзошгүй хэмээх шалтгаар АНУ-ын Төрийн Департамент, ОХУ-д хориг арга хэмжээ авснаар рублийн ханш суларчээ.

Эх сурвалж: Reuters, Troweprice

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	19,388.47	0.74% ▼
Dow Jones	АНУ	25,313.14	-0.59% ▼
S&P 500	АНУ	2,833.28	-0.25% ▼
Nasdaq	АНУ	7,839.11	0.35% ▲
S&P/TSX	Канад	16,326.51	-0.57% ▼
FTSE 100	Их Британи	7,667.01	0.10% ▲
S&P/ASX 200	Австрали	6,278.40	0.70% ▲
Nikkei 225	Япон	22,298.08	-1.01% ▼
Hang Seng	Хонг Конг	28,366.62	2.49% ▲

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.7%	110.83
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.6%	97.80
Mongol 2022 (Чингис)	USD	5.1%	96.73
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.8%	113.12
DBM' 23 (Самурай)	JPY	1.5%	104.41
TDBM' 2020	USD	9.3%	106.52

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.067	-0.01 ▼
Libor 3M	2.319	-0.02 ▼
Libor 6M	2.512	-0.01 ▼
Libor 1YR	2.816	-0.01 ▼
US 6M Bond	2.211	0.01 ▲
US 2YR Bond	2.588	-0.07 ▼
US 3YR Bond	2.660	-0.08 ▼
US 5YR Bond	2.721	-0.11 ▼
US 10YR Bond	2.852	-0.11 ▼

Валютын ханш /төг/

Валют	2018.08.10	Өөрчлөлт
USD	2,455.99	-0.06% ▼
CNY	358.24	0.47% ▲
EUR	2,816.04	-0.90% ▼
RUB	36.75	-5.04% ▼
KRW	2.17	-0.46% ▼
JPY	22.19	0.96% ▲

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,208.52	-0.53% ▼
Мөнгө /spot/	USD/t oz.	15.28	-0.91% ▼
Зэс	USD/lb.	273.10	-1.18% ▼
Нүүрс	USD/MT	106.70	0.33% ▲
WTI газрын тос	USD/bbl.	67.54	-1.39% ▼
Brent газрын тос	USD/bbl.	72.58	-0.86% ▼
Байгалийн хий	USD/MMBtu	2.92	2.46% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2018. VI	7.20%
Бодлогын хүү	2018. VI	10.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018. VI	10.00%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018. VI	12.30%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018. VI	5.20%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018. VI	18.00%
Зээлийн дундаж хүү /валют/	2018. VI	10.20%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 41 компанийн 480.8 сая төгрөгийн 1,708,274 ширхэг хувьцаа арилжигдав.


“Усжуулах” /CMD/ компанийн хувьцаа 15.00%-аар буюу хамгийн ихээр өсч 690 төгрөгт хүрч хаагдсан бол “Ноёт хайрхан” /NIE/ компанийн хувьцаа 22.22%-аар буурч 700 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл дээр нийт 468 ширхэг үнэт цаас 46.9 сая төгрөгөөр арилжаалагджээ.


8-р сарын 10-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,365.8 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 19,388.47 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.74%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2018 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	527.7
Зах зээлийн үнэлгээ	2,365,751.3

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	19,388.47	-0.74% ▼
MSE I индекс	9,460.87	-0.61% ▼
MSE II индекс	9,280.17	-0.04% ▼

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Монголын цахилгаан холбоо	320,511	151,710,535
АПУ	170,024	101,324,864
ЛэндМН ББСБ	929,328	65,670,122
Монгол Базальт	159,453	58,359,316
Таван Толгой	3,942	32,919,150

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Усжуулах	690.00	15.00% ▲
Хөсөг трейд	1,644.00	14.97% ▲
Ремикон	40.00	14.97% ▲
Мерекс	33.00	10.00% ▲
УБ БҮК	400.00	8.11% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Ноёт хайрхан	700.00	-22.22% ▼
Монноос	2,500.00	-13.79% ▼
Бөхөг	2,700.00	-10.00% ▼
Улсын их дэлгүүр	450.00	-10.00% ▼
Силикат	140.00	-6.67% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Голомт Капитал	288,932,607
Монгол секюритиес	152,444,892
Мирэ Эссет Секьюритис Монгол	124,821,904
Гаули	85,082,665
БиДиСек	80,933,470

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	600.00	638,509
Таван толгой	8,305.00	437,384
МИК	10,990.00	227,595
Говь	24,980.00	194,872
Сүү	210.00	72,240

ЗГҮЦ БОЛОН КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-BD-01/18/19-A0285-13.745	140	14,000,000	100,000	100,000	104	13.745%
2	ZGEB-BD-11/04/19-A0230-18	281	28,248,930	100,530	100,530	104	18.000%
3	ZGEB-BD-14/03/19-A0219-18	47	4,700,000	100,000	100,000	104	18.000%

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Симбол	Компанийн нэр	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Нийт ногдол ашиг /сая төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр	Хуваарилах хэлбэр
1	ERS	Монгол алт	150.00	39.88	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор	Тодорхойгүй
2	TEE	Тээвэр дархан	500.00	81.67	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор	Тодорхойгүй
3	TTL	Таван Толгой	2,410.00	126,923.13	2018.04.16	2018.04.03	2018.06.12-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
4	EER	Ариг гал	21.33	74.21	2018.04.25	2018.04.02	2018.09.01-с	Тодорхойгүй
5	BDL	Могойн гол	100.00	82.96	2018.04.26	2018.01.18	2018.06.26-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
6	DSS	Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ	56.60	7.66	2018.03.07	2018.03.27	2018.07.02-с	Тодорхойгүй
7	TAL	Талын гал	50.00	34.71	2018.03.05	2018.04.26	2018.12.31-ний дотор	Тодорхойгүй
8	BRC	Барилга корпораци	700.00	28.46	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй	Тодорхойгүй
9	AND	Анд-Энерги	1.27	99.15	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй	Тодорхойгүй
10	SUL	Жуулчин дюти фрий	10,000.00	653.62	2018.02.23	2018.04.11	2018.05.01-с	Компанийн байранд
11	GTL	Гутал	1,270.00	83.01	2018.02.19	2018.03.18	2018.07.06-с	Тодорхойгүй
12	BNG	Баянгол зочид буудал	355.00	150.19	2018.02.19	2018.04.06	2018.09.01-с	Компанийн байранд
13	APU	АПУ	10.00	10,641.82	2018.02.19	2018.03.29	2018.05.17-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
14	BTG	Баянтээг	100.00	25.26	2018.02.19	2018.03.12	2018.06.01-ний дотор	ҮЦТХТ-ийн данс
15	MIE	Материалимпекс	10.00	13.68	2018.02.19	2018.03.26	2018.04.17-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
16	HRD	Хүрд	497.00	67.23	2018.02.15	2018.02.23	2018.06.30-ны дотор	Тодорхойгүй
17	SUU	Сүү	3.00	1,032.00	2018.02.14	2018.04.05	2018.06.04-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
18	MNP	Монгол шуудан	3.68	366.48	2018.02.13	2018.04.13	2018.06.05-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
19	MMX	Махимпекс	100.00	380.07	2018.02.13	2018.04.05	2018.10.01-с	Компанийн байранд
20	TCK	Талх чихэр	170.00	174.03	2018.02.12	2018.04.06	2018.07.01-с	Компанийн байранд
21	GHC	Ган Хийц	100.00	24.25	2018.02.09	Тодорхойгүй	Тодорхойгүй	Тодорхойгүй
22	ADL	Адуун чулуун	130.00	409.67	2018.02.07	2018.03.01	2018.06.26-нд олгов	ҮЦТХТ-ийн данс
23	TAN	Тахь-ко	108.00	128.52	2018.02.05	2018.03.30	2018.05.01-ний дотор	ҮЦТХТ-ийн данс
24	UBH	Улаанбаатар хивс	100.00	40.48	2018.02.05	2018.02.26	2018.05.01-с	ҮЦТХТ-ийн данс
25	GOV	Говь	220.00	1,716.25	2018.02.02	2018.03.27	2018.04.24-с олгов	Компанийн байранд
26	HRM	Гермес центр	5.00	392.72	2018.01.24	2018.02.15	2018.04.12-нд олгов	ҮЦТХТ-ийн данс

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн үнэт цаасны захиалгыг 2018 оны 8-р сарын 16-ны өдрийг хүртэл авч байна

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй “Хөвсгөл Алтандуулга” ХК нь газар тариалан болон гурилын үйлдвэрийн тоног төхөөрөмж худалдан авах, зээлийн эх үүсвэрийг бууруулах, эргэлтийн хөрөнгө санхүүжүүлэх зорилгоор нэмж хувьцаа гаргаж байгаа билээ. Тус компани нэмж гаргасан хувьцааны 3,328,600 ширхэг хувьцааг тогтоосон үнийн аргаар стратегийн хөрөнгө оруулагч нарт нэг бүрийг нь 850 төгрөгөөр, 1,177,000 ширхэг хувьцааг олон нийтэд захиалга бүртгэлийн аргаар санал болгож байгаа бөгөөд доод үнийг 850 төгрөгөөр тогтоосон байгаа аж.

“Хөвсгөл Алтандуулга” ХК-ийн үнэт цаасны захиалгыг 2018 оны 8 дугаар сарын 8-ны өдрөөс 2018 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн 13:00 цаг хүртэл авч байна.

“АПУ” ХК 33.7 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ

Хөрөнгийн биржийн I ангилалд бүртгэлтэй хувьцаат компаниуд хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайланг аа олон нийтэд нээлттэй хэлбэрээр танилцуулж байгаа билээ.

“АПУ” ХК одоогийн байдлаар 10 охин компани, 1 хараат компани болон 2,300 ажилтантай үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээр охин болоод хараат компаниуд нь сүү, сүүн бүтээгдэхүүн, ус, ундаа, шүүс, архи, шар айраг гэх мэт 218 нэр төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн зах зээлд борлуулж байгаа аж.

“АПУ” ХК энэ оны хагас жилийн байдлаар 201.2 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллаж, улсын төсөвт 120 тэрбум төгрөгийн татварыг төвлөрүүлсэн байна. Ингэснээр компанийн цэвэр ашиг 33.7 тэрбум төгрөгт хүрлээ.

Тус компани үйлдвэр, үйл ажиллагааны өргөтгөл хийх зорилгоор зээлсэн 100 гаруй сая ам.долларын өрийг 2019 оны 4-р сард барагдуулах ёстой ч уг өрийн 30 орчим тэрбум төгрөгийг энэ оны 8-р сард төлж барагдуулах юм байна.

Энэ онд “АПУ” ХК 133.7 сая литр бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 433.7 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллахаар төлөвлөж байгаа талаар “АПУ” ХК-ийн гүйцэтгэх захирал мэдээллээ.

“Говь” ХК 2018 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа танилцууллаа

Говь хувьцаат компани нь 2018 оны эхний хагас жилийн байдлаар нийт 2,005 ажилтантай дотоодод 8 салбар дэлгүүр, олон улсад 13 орны 34 хотод 5 салбар, 53 франчайз дэлгүүртэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Эхний хагас жилийн байдлаар Говь хувьцаат компанийн борлуулалтын орлого 55.6 тэрбум төгрөг хүрсний 36.5 тэрбум төгрөгийг дотоод зах зээлд, 19.2 тэрбум төгрөгийг гадаадад зах зээлд борлуулсан ба энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 64 хувиар өсчээ. Ийнхүү “Говь” ХК 2018 оны эхний хагас жилийн борлуулалтын төлөвлөгөөнийхөө 99 хувьд хүрч ажилласан байна. Компанийн гадаад борлуулалт төлөвлөгөөнд хүрч чадалгүй 93 хувийн гүйцэтгэлтэй байсан бол дотоодын борлуулалт 102 хувьтай байв. Цэвэр ашгийн хэмжээ 4.4 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 30 хувиар өссөн ч төлөвлөгөөний гүйцэтгэлээр 80 хувьтай байжээ. Энэ нь үйл ажиллагааны зардал харьцангуй нэмэгдсэнтэй холбоотой аж.

Эх сурвалж: Ти Ди Би Капитал ҮЦК

“МИК Холдинг” ХК-ийн 2018 оны хагас жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан гарлаа

“МИК Холдинг” ХК энэ оны эхний хагас жилд нийт 268.2 тэрбум төгрөгийн дүн бүхий ипотекийн зээлээр баталгаажсан бонд нэмж гаргажээ. Мөн тус хугацаанд давуу эрхтэй бондын үндсэн төлбөрт нийт 118.6 тэрбум төгрөг, давуу болон энгийн бондын купоны төлбөрт 67.2 тэрбум төгрөгийг төлсөн байна.

Компанийн хүүгийн орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12.7 хувиар өсч 115.6 тэрбум төгрөгтэй тэнцлээ. Компанийн борлуулалт, маркетингийн зардал 545 сая төгрөгөөр, ерөнхий ба удирдлагын зардал 3.1 тэрбум төгрөгөөр ихэссэн байна. Ингэснээр нийт цэвэр ашиг өмнөх оны мөн үеэс 14.7 хувиар буурч 30.8 тэрбум төгрөгтэй тэнцжээ.

“Сүү” ХК 2018 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа танилцууллаа

Сүү хувьцаат компани нь 2018 оны эхний хагас жилийн байдлаар 5 аймгийн 30 гаруй чиглэлээс 2,500 гаруй бэлтгэн нийлүүлэгч, фермерүүдээс сүү татан авч аймгийн төвүүд, томоохон суурин газрууд болон Улаанбаатар хотын 9 дүүрэгт 3,000 гаруй цэгт түгээлт хийн ажиллаж байна. Сүү хувьцаат компани нь 70 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг зах зээлд худалдаалж байгаа бөгөөд нийт 340 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байгаа аж. 2018 оны эхний хагасд цэвэр борлуулалтын орлого 35.1 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 45.8 хувиар өссөн бөгөөд нийт ашгийн хэмжээ 2.7 тэрбум төгрөгөөр буюу 46.3 хувиар өссөн байна. Харин цэвэр ашгийн дүн 2.2 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 95.2 сая төгрөгөөр буурсан нь ерөнхий, удирдлагын зардал 2.8 тэрбум төгрөгөөр өссөнтэй холбоотой.

“Монгол шуудан” ХК-ийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан гарлаа

“Монгол шуудан” ХК хот, хөдөө орон нутагт байрлах нийт 39 салбартайгаар үйл ажиллагаагаа явуулж байгаа аж.

2018 оны эхний хагас жилийн байдлаар борлуулалтын орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 32.1 хувиар өсч 7.8 их наяд төгрөгтэй, борлуулсан бүтээгдэхүүний өртөг 29 хувиар өсч 6.7 их наяд төгрөгтэй тэнцжээ. Нийт борлуулалтын орлогын 70 орчим хувийг ложистикийн үйлчилгээний орлого бүрдүүлж байна. Ингэснээр “Монгол шуудан” ХК-ийн цэвэр ашиг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 50.2 хувиар өсч 906.7 сая төгрөгт хүрлээ.

“Тавантолгой” ХК-ийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан гарлаа

“Тавантолгой” ХК-ийн борлуулалтын орлого эхний хагас жилд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 64 хувиар буурч, 90.5 тэрбум төгрөгт хүрсэн бол цэвэр ашгийн хэмжээ 66 хувиар буурч 19.3 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Тус компани 2018 оны эхний хагас жилд 4 сая тонн нүүрс олборлон борлуулах төлөвлөгөөтэй байсан боловч Сангийн яам болон Мэргэжлийн хяналтын байгууллага борлуулалтын үйл ажиллагааг 2 сарын хугацаатай зогсоосноос үүдэн төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй ажээ.

Эх сурвалж: Ти Ди Би Капитал ҮЦК

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Нүүрсний экспортын биет хэмжээ буурсан ч орлого нь өсчээ

Манай нүүрсний тээврийн гол “судас” болсон Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн автозамыг 8-р сарын 9-ний өдрийн 15.00 цагт нээсэн байна. Ингэснээр Монгол улсад ойролцоогоор хоёр тэрбум ам.долларын орлого авчирдаг нүүрсний экспорт хэвийн үргэлжлэх боломж бүрдэв. 7-р сараас эхлэн нийт нутгаар их хэмжээний аадар бороо орсноос Гашуунсухайт чиглэлийн замын хэд хэдэн хэсэг эвдэрч сүйджээ. Тиймээс тус автозамын тээврийг өнгөрсөн долоо хоногт түр зогсоосон юм. Тэгвэл энэ долоо хоногт замын эвдэрсэн хэсгийг засаж, тэгшлэн, тээвэрлэлт хийхэд бэлэн болгожээ. Хэдийгээр гол зам нь түр засвартай байсан ч Монгол улсын нүүрсний экспорт үргэлжилж байсан юм. Учир нь нүүрсний компаниуд Цагаанхадны боомтод нөөцөлсөн нүүрсээ урд хөршид нийлүүлжээ. Энэ оны эхний долоон сарын байдлаар Монгол улс 20.5 сая тонн нүүрс экспортолж, 1.6 тэрбум ам.доллар олжээ. Хэдийгээр экспортолсон нүүрсний биет хэмжээ өмнөх оны мөн үеэс 300 мянган тонноор буурсан ч бидний олсон орлого 206 сая ам.доллараар нэмэгдсэн байна.

Тонн нүүрсний ханш өмнөх оны мөн үеэс 10 орчим хувиар өндөр байгаа нь биет хэмжээний уналтыг нөхжээ. Өнгөрсөн хоёр сарын хугацаанд зэсийн ханш 1000-1500, алтны 100-150 ам.доллараар буурсан байхад нүүрс болон төмрийн хүдрийн ханш тус бүр 10 орчим хувиар өссөн байна. Монгол улс өнгөрсөн долоон сарын хугацаанд 3.9 сая тонн төмрийн хүдэр нийлүүлж, 181 сая ам.долларын орлого олсон. Төмрийн хүдрийн экспорт биет хэмжээгээр 20 хувиар өссөн байна. Их гүрнүүдийн хооронд асаж буй худалдааны дайн таваарын зах зээлийг уналт руу хөтөлж байгаа ч зарим төрлийн түүхий эдэд төдийлэн нөлөөлөхгүй байна. Ялангуяа, гангийн үндсэн орц болох коксжих нүүрс болон төмрийн хүдрийн ханшид худалдааны дайнаас илүү Хятадын байгаль орчны төлөөх бодлого хүчтэй нөлөөлж байна. БНХАУ, АНУ-ын худалдааны дайны түгшүүрийг дагаад зэсийн үнэ зургадугаар сараас хойш 15 хувиар буурсан бол төмрийн хүдрийнх өсөн хувиар өсжээ. Нүүрсний экспортын орлого 206 сая ам.доллараар нэмэгдсэн байна.

Ер нь коксжих нүүрс болон төмрийн хүдрийн ханш хаана хүрэхийг эдгээр түүхий эдээс “төрдөг” гангийн зах зээл заадаг. Тэгвэл манай улсын экспорт, цаашлаад эдийн засгийн өсөлтийг тодорхойлдог гангийн зах зээл нь урд хөршийн орон сууц, бүтээн байгуулалтын салбараас шууд хамаардаг билээ. Мөн Хятадын үндэсний статистикийн товчооны мэдээллээр энэ оны зургадугаар сард тус улсын томоохон 70 хотод орон сууцны үнэ эрчимжжээ. Жилийн дүнгээр шинэ орон сууцны үнэ таван хувиар дээшилж, өсөлт нь эрчимжив. Ингэснээр сүүлийн зургаан сар тасралтгүй суларсан орон сууцны үнэ өнгөрсөн зургадугаар сард ялимгүй сэргэж эхэлсэн байна. Энэ нь гангийн эрэлтэд түр зуурын эерэг хүлээлт төрүүлж буй. Гэвч Хятадын макро эдийн засгийн өсөлт сүүлийн найман жилийн доод цэгт хүртлээ саарчихаад байгаа нь дунд хугацааны сөрөг төлөв дагуулж байна. Гэхдээ урд хөрш утаа зэрэг байгаль орчны бохирдолтой тэмцэхийн тулд гангийн үйлдвэрлэл болон түүхий эдийн чанар стандартыг өндөрсгөсөн. Энэ нь сайн чанарын таваарын ханшид дэмжлэг болж буй. Байгаль орчноо хамгаалж, гангийн зах зээлийн илүүдлийг арилгах Хятадын зорилт төмрийн хүдрийн үнийг өсгөж, сүүлийн зургаан сарын дээд цэгт хүргээд байна. Байгаль орчны төлөөх Бээжингийн санаачилга ирэх саруудад өндөр чанартай нүүрс хийгээд төмрийн хүдрийн эрэлтийг дэмжиж, урт хугацаанд гангийн зах зээлийн тэнцвэржүүлэхээр байгаа. Rio Tinto группийн гүйцэтгэх захирал Жан Себастьян Жак Хятадын гангийн аж үйлдвэрт бүтцийн шинэчлэл хийгдэх нь гарцаагүй.

Гэхдээ энэ нь үйлдвэрлэлийг бууруулах бус өндөр чанарын түүхий эдийг илүү шаардана хэмээн дүгнэжээ. Өөрөөр хэлбэл, гангийн голлох түүхий эдүүд болох коксжих нүүрс болон төмрийн хүдрийн ханш энэ оныг дуустал тогтвортой байх төлөвтэй. Мөн өндөр агууламжтай сайн чанарын түүхий эдийн ханш цаашид ч өсөхөөр байна. Хятадын гангийн гарц зургадугаар сард жилийн дүнгээр 7.5 хувь өсөж, дээд хэмжээ буюу 80.2 тоннд хүрснийг ANZ фирм мэдээлсэн байна. Fitch агентлагийн тооцоогоор 2016 оны зургадугаар сараас хойш Хятад улс гангийн хүчин чадлаа 260 сая тонноор бууруулсан нь ханш чангарах суурь нөхцөл болжээ.

Эх сурвалж: Засгийн газрын мэдээ сонин

Алтны роялтиг 2.5 хувь болгосон хуулийн хугацаа ирэх онд дуусгавар болно

Алтны роялтиг 2.5 хувь болгосон хуулийн хугацаа ирэх онд дуусгавар болох бөгөөд хуулийн хугацааг сунгуулах талаар холбогдох газарт хандахаар төлөвлөж буйг Төвбанкны мэргэжилтнүүд онцлов.

Швейцарийн хөгжлийн агентлагийн тогтвортой бичил уурхай төслийн хүрээнд алтны нийлүүлэлтийн сүлжээг боловсронгуй болгох, алтны худалдааны төвлөрлийг сааруулах зорилгоор алтны сорьц тогтоох, худалдан авах нэг цэгийн үйлчилгээний төвийг ирэх 9 дүгээр сарын сүүлчээр орон нутагт нээх юм байна.

Сорьцын лабораторийг байгуулснаар орон нутагт нь алт худалдан авах боломж бүрдэж, алт тушаалтын нийлүүлэлтийн явц олон шат дамжлага дамжихааргүй болж байна. Түүнчлэн алт үйлдвэрлэгчид Монголбанкны тухайн өдрийн ханшаар алтаа тушаах боломж бүрдэх юм. Өнгөрсөн онд алтны тушаалт нэмэгдэж, 700 гаруй сая ам.доллараар валютын нөөцийг нэмсэн бол энэ онд 800 сая ам.доллар давах хүлээлттэй байна.

Эх сурвалж: Montsame.mn

“Оюу толгой”-н алтны үйлдвэрлэл 19 хувиар нэмэгджээ

“Оюу толгой” ХХК-ийн тээрийн ашиглалтын түвшин дээшлэн, тэсэлгээний үйл ажиллагаа сайжирсантай холбоотой боловсруулсан хүдрийн хэмжээ өмнөх улирлаас 6.3 хувиар нэмэгджээ.

Тодруулбал хоёрдугаар улиралд үйлдвэрлэсэн баяжмал дахь зэсийн хэмжээ өмнөх улирлаас 1.5 хувь нэмэгдсэн нь тээрийн ашиглалтын түвшин дээшилсэн, 6 дугаар үе шатны хүдрийн нөөцийн агуулга харьцангуй бага байсантай холбон тайларлаж байна.

Мөн хоёрдугаар улирлын тайлан мэдээгээр алтны үйлдвэрлэл 19 хувиар нэмэгдсэн нь тээрийн ашиглалтаас гадна “4А” үе шатны хүдэр дэх агуулга, метал авалт нэмэгдсэнээс шалтаалсан байна. Туркойз Хилл компани “Оюу толгой” төслийг энэ онд 125-155 мянган тонн баяжмал дахь зэс, 240-280 мянган унци баяжмал дахь алт үйлдвэрлэнэ хэмээн төсөөлсөн бол хүдрийн хэмжээ 2018 оны эцэст 40 сая тоннд хүрэх төлөвтэй байгаа аж.

Гүний уурхайн хөндлөн нэвтрэлтийн ажил ахицтай явж байгаа бөгөөд тавдугаар босоо амыг амжилттай барьж гүйцэтгэн төлөвлөгөөт гүн болох 1,178 метр, 6.7 метрийн өргөнд хүрснийг тус компаниас мэдээллээ.

Оюутолгой 2020 оны дунд үеэс анхны хүдрийг биетийг олборлон эхэлж 2021 оноос тогтвортой үйлдвэрлэл эхлэхээр төлөвлөж байгаа юм.

Эх сурвалж: Montsame.mn

БУСАД МЭДЭЭ



Олон улсын валютын сангаас өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн тав дахь шатны үнэлгээг хийжээ

Олон улсын валютын сангийн 5 дахь шатны үнэлгээг Жэф Готтлибээр ахлуулсан ОУВС-гийн ажлын хэсэг долдугаар сарын 25-наас наймдугаар сарын 6-ны өдрүүдэд Монгол Улсад ажиллаж, хөтөлбөрийн хэрэгжилт, Засгийн газар, Монголбанкнаас авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээний хэрэгжилт, тоон үзүүлэлтүүдийн үнэлгээг урьдчилсан байдлаар хийжээ.

Ажлын хэсгийн үнэлгээний урьдчилсан дүгнэлтэд үндэслэн тайлан боловсруулж, ОУВС-гийн удирдлагаар батлуулсны дараа Захирлуудын зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэр нь гарна.

Хөтөлбөрийн хүрээнд нийтдээ 314.5054 саяын зээлжих тусгай эрх буюу ойролцоогоор 434.3 сая ам.долларын зээл олгох юм. Харин энэ удаагийн яриа, хэлэлцээрүүд ОУВС-гийн дэмжлэгтэй хэрэгжиж буй хөтөлбөрийн хэрэгжилт, дунд хугацааны төлөв болон өрийн тогтвортой байдал, санхүүгийн тогтолцоог шинэчлэх болон ядуу иргэдийг хамгаалах замаар өсөлтийг бий болгоход шаардлагатай байгаа бодлогын болон бүтцийн өөрчлөлтүүд зэрэг асуудлын хүрээнд өрнөжээ.

Ажлын хэсгийн айлчлалыг дүгнэж ноён Готтлиб дараах мэдэгдлийг гаргасан байна.

Тодруулбал “Ажлын хэсэг Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн тав дахь шатны үнэлгээг гүйцэтгэхэд шаардлагатай бодлогын хүрээнд дэх үр дүнтэй яриа, хэлэлцээрүүдийг эрх баригчидтай хийлээ. Сүүлийн үеийн макро эдийн засгийн гүйцэтгэл эерэг байж, гол зорилтууд хангагдаж, эдийн засаг сайн сэргэж байгаа боловч тодорхой хэмжээний эмзэг байдал оршсоор байна. “Ялангуяа санхүүгийн салбарыг чадавхжуулж, шинэчлэх зорилготой бодлого болон бүтцийн өөрчлөлтийн хувьд томоохон ахиц ажиглагдсан. Макро эдийн засгийн бодлогын хүрээнд хэлэлцээрүүд ойрын хугацаанд үргэлжилнэ” гэжээ.

Эх сурвалж: Montsame.mn

Валютын албан нөөц 3.2 тэрбум ам.доллартай тэнцжээ

Эдийн засгийн төлөв байдлыг тодорхойлогч төлбөрийн тэнцэл энэ оны эхний таван сарын байдлаар 201.7 сая ам.долларын ашигтай гарсан нь дунд хугацаанд төгрөгийн ханш тогтвортой байхад нөлөөлнө гэдгийг Монголбанкнаас тодотгосон.

Мөнгөний нийлүүлэлт гадаад эх үүсвэр буюу гадаадын шууд хөрөнгө оруулалт, ОУВС-гийн хөтөлбөрийн санхүүжилт болон экспортын орлогын нөлөөгөөр нэмэгдэж байгаа юм.

2018 оны эхний таван сарын байдлаар шууд хөрөнгө оруулалт 643.6 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 200 орчим сая ам.доллараар нэмэгдсэн байна.

Ингэснээр валютын албан нөөц 3.2 тэрбум ам.доллартай тэнцжээ. Засгийн газар он гарсаар томоохон дүнтэй өрийн эргэн төлөлт хийсэн ч валютын нөөц өмнөх жилтэй харьцуулахад нэмэгдээд байгаа аж.

Эх сурвалж: Montsame.mn



Махны экспорт 80 тэрбум төгрөг давлаа

Энэ оны эхний хагаст махны экспорт 2014 оны мөн үеийнхээс 20, 2016 оныхоос тав дахин өссөн байна. Энэ онд монгол малын махны экспорт өсч, сүүлийн жилүүдэд үзэгдээгүй их хэмжээний экспортын орлогыг Монгол улсад төвлөрүүлжээ. Оны эхний хагаст 80 тэрбум төгрөг даваад буй махны экспорт энэ жилийн эцэст 200 тэрбум төгрөгт хүрэх төлөвтэй байна.

Өнгөрсөн нэг жилийн хугацаанд Монголоос голлон адууны мах гадаад зах зээлийг чиглэж байсан бөгөөд нийт экспортын 90 хувийг бүрдүүлж байв. Гэтэл он гарсаар махны экспорт төрөлжиж, үхэр, хонь, ямааны мах нийлүүлж эхэлсэн байна. Түүнчлэн гарын таван хуруунд багтахар улсад бүтээгдэхүүн нийлүүлж байсан бол өдгөө 10-аад улсад экспортолж эхэлжээ. Үүнээс Иран, Хонконг, Вьетнамыг чиглэх махны экспорт багагүй хувиар нэмэгдсэн.

Махны нийт орлогын 80 хувийг адууны мах бүрдүүлсэн бол хонь, ямаа, үхрийн махны нийлүүлэлт өсчээ. Адууны махны экспортын орлого өмнө оны мөн үеэс хоёр дахин өссөн бол хониных гурван дахин өссөн байна. Махнаас гадна амьд малын экспортын орлого 11 дахин өсчээ. Ингэснээр мах, махан бүтээгдэхүүний экспортын орлого 24 сая ам.долларт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 2-3 дахин өндөр өсөлт үзүүллээ. Энэ дүнг амьд малын экспортын орлоготой нийлүүлбэл нийт дүн нь 32.6 сая ам.доллар хүрч байгаа юм.

Эх сурвалж: Засгийн газрын мэдээ сонин

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.